



СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№100
/313/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МЭДЭЭ

2022.05.27

тусгай дугаар



Монгол цэрэг энхийн үйлсэд

ЦЭНХЭР ДУУЛГАТ ЦЭРГИЙН БҮСГҮЙЧҮҮД ЧУУЛЖ БАЙНА



Монгол цэрэг НҮБ-ын болон олон улсын бусад ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойн хүрээнд “Энхийг сахиулагч эмэгтэйчүүдийн алдрыг сурталчлах өдөрлөг”-ийг Соёлын төв өргөөнд зохион байгуулж байна.

Тус арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх, УИХ-ын болон Засгийн газрын эмэгтэй гишүүд, БХЯ, ЗХЖШ, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын удирдлага, гадаад орнуудаас Монгол Улсад суугаа Элчин сайд, Батлан хамгаалахын атташе нар, НҮБ-ын суурин төлөөлөгчид, эмэгтэй энхийг сахиулагчид болон Зэвсэгт хүчин, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын эмэгтэй цэргийн алба хаагчдын төлөөлөл 1000 бүсгүй оролцож байна.

Эмэгтэй энхийг сахиулагчдад хүндэтгэл үзүүлэх энэхүү өдөрлөгийн арга хэмжээг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр нээж үг хэлэв. Тэрээр Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг сахиулагчид тэр дунд эмэгтэй энхийг сахиулагчдын талаар бахархам гавьяаг индэр дээрээс дурдаж байв.

Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагаанд дахь оролцоо нь анхны цэргийн 2 ажиглагч офицерыг 2002 онд Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсад явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд илгээснээс эхэлсэн бөгөөд одоогийн

байдлаар давхардсан тоогоор 20000 гаруй цэргийн алба хаагч энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгээд байгаагийн 873 нь эмэгтэй цэргийн алба хаагч гэсэн бахдам тоо байдаг.

НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд 1957 онд анх удаа эмэгтэй энхийг сахиулагч үүрэг гүйцэтгэсэн бөгөөд 2022 оны дөрөвдүгээр сарын байдлаар НҮБ-ын энхийг сахиулах 12 ажиллагаанд 76 мянга гаруй цэрэг, цагдаагийн алба хаагч үүрэг гүйцэтгэж байгаагийн долоон хувь нь эмэгтэйчүүд байна. Харин Монгол Улсаас анх удаа 2005 онд Баруун Сахарт явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах “MIN-URSO” ажиллагаанд хурандаа Н.Нямжаргал ахмад цолтой байхдаа цэргийн ажиглагч офицераар үүрэг гүйцэтгэснээр Монгол Улсын Зэвсэгт хүчний эмэгтэй цэргийн алба хаагчдын шанг татсан түүхтэй. Өнөөдрийн байдлаар манай улс НҮБ-д цэрэг хандивлагч орнуудаас эмэгтэй энхийг сахиулагчдын тоогоороо 26 дугаар байрт эрэмбэлэгдэж байгаа бол Этиоп болон Руанда улсууд тус бүр 500-гаас илүү эмэгтэй энхийг сахиулагчдыг ажиллагааны газар оронд илгээснээр жагсаалтыг тэргүүлж байна.

Цаашид ч Монгол Улсын Зэвсэгт хүчин “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс”, “Зэвсэгт хүчний тухай”, “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай” хууль,

“Зэвсэгт хүчний байгуулалтыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”, болон Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030” баримт бичгийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багуудыг НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгүүлэх, энхийг сахиулах ажиллагааны чадавх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Түргэн байрлах хүчний рот, Инженерийн рот, Цэргийн хээрийн хоёрдугаар шатны эмнэлгийг НҮБ-ын үнэлгээний багт танилцуулан, үнэлүүлэн ажиллаж байгаа юм.

Мөн Монгол Улсын Зэвсэгт хүчнээс үүрэг гүйцэтгэж буй мотобудлагын батальонууд нь орон нутгийн иргэдэд чиглэсэн Иргэн-цэргийн харилцааны болон сайн үйлсийн хүмүүнлэгийн үйл ажиллагаанууд тэр дундаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл ахуйн орчин нөхцөлийг сайжруулах, сурч боловсрох нөхцөл байдлыг бүрдүүлэх, инженерийн тусалцаа дэмжлэг үзүүлэх зэрэг олон төрлийн үйл ажиллагааг зохион байгуулдаг. Тиймээс дээр дурдсан олон талт ажиллагаанд энхийг сахиулагч бүсгүйчүүдийн үүрэг оролцоо чухал агаад эрхэм билээ.

Тийм ч учраас “Энхийг сахиулагч эмэгтэйчүүдийн алдрыг сурталчлах өдөрлөг”-ийг зохион байгуулж, эрэлхэг

энхийг сахиулагч бүсгүйчүүддээ ийнхүү хүндэтгэл үзүүлж буй юм. Өдөрлөгийн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх нийт бүсгүйчүүдэд хандаж баяр хүргэн үг хэлж, шилдэг эмэгтэй энхийг сахиулагчдад дурсгалын зүйл гардуулав. Мөн “Монголын эмэгтэй энхийг сахиулагчид” видео танилцуулгаас гадна Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг сахиулах болон олон үндэстний цэргийн ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн эмэгтэй цэргийн алба хаагчдын үүрэг гүйцэтгэлийг сурталчилсан гэрэл зургийн болон Монгол цэргийн музейн үзүүлэлэнд үзэсгэлэн дэлгэжээ. Тус үзэсгэлэнд НҮБ-ын энхийг сахиулах “UNAMID”, “UNMIL”, “UNMISS” ажиллагаа, ИБНАУ-д явагдсан “Шийдвэртэй дэмжлэг” ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн эмэгтэй цэргийн алба хаагчдын үүрэг гүйцэтгэлийг харуулсан гэрэл зургийн болон тухайн цэргийн баг, цэргийн алба хаагчдын ашиглаж байсан эд өлгийн зүйлс багтсан байна.

Мөн Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга, Хилийн цэргийн дуу бүжгийн чуулга, Цагдаагийн “Сүлд” чуулга зэрэг мэргэжлийн урлагийн байгууллагуудаас гадна Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын авьяаслаг энхийг сахиулагчдын оролцсон нэгдсэн тоглолтыг толилууллаа.

Н.Сувд: УЛСЫН БААТРУУД, ОЛОН УЛСЫН ЭНХТАЙВНЫ ТОМ ЗҮТГЭЛТНҮҮД ТӨРНӨ ГЭДЭГТ ИТГЭЛ ТӨГС БАЙНА

Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн соёрхолт, Ардын жүжигчин



-НҮБ-ын энхийг сахиулах болоод олон улсын бусад ажиллагаанд эмэгтэй цэргийн алба хаагчид маань оролцож, дэлхий нийтээрээ энх тайвнаар зэрэгцэн орших ариун үйлсэд хувь нэмрээ оруулж байгааг хараад би өөрийн эрхгүй бахархдаг юм. Угаасаа манай монгол бүсгүйчүүдэд бусдаас ялгарах яс цусанд нь шингэсэн нэг чанар байдаг. Өөрөөр хэлбэл, аав ээж, хань ижил, үр хүүхэд, ах дүү амраг садан, найз нөхдөөсөө эхлээд улс гэрээ эмхлэн төвхнүүлэх тийм их сэтгэлийн хатыг зүрх тархи, сэтгэл оюундаа шингээж төрсөн байдаг. Их түүхэнд мөнхөрсөн эрэлхэг хатдын залгамж чанар, агуу дайчин уламжлал шүү дээ энэ чинь. Энэ л жимээр, энэ залгамж чанарыг түүчээлж, энхийн замаар дэлхий дахинд энх амгаланг тогтоолцож яваа энхийг сахиулагч

бүсгүйчүүдийн дотроос генерал цолтон ч төрлөө. Өшөө цаашаа улсын баатрууд, олон улсын энхтайвны том зүтгэлтнүүд төрнө гэдэгт итгэл төгс байна. Монгол цэрэг энхийн үйлсэд замнаж эхэлсний 20 жилийн ой, Олон улсын энхийг сахиулагчдын өдрийн босгон дээр буюу өнөөдөр энэхүү гэгээн үйлсээ, ажил албаа ард түмэнд сурталчлан таниулж, бахархан чуулж байгаа нь зүй ёсны хэрэг гэж харж байна. Эх орныхоо бахархал омогшил нь болсон цэнхэр дуулгат энхийг сахиулагч эрхэмсэг бүсгүйчүүддээ болон нийт энхийг сахиулагчдадаа баярын мэнд хүргэж, ажил хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе. Та бүхнийг амгалан төрийн алтан соёмбо үргэлж ивээх болтугай.



Монгол цэрэг энхийн үйлсэд

Г.Болор: БИД ЭХ ДЭЛХИЙН ЭНХ АМГАЛАНГИЙН ТӨЛӨӨХ АРИУН ҮЙЛСТ УЛАМ ИХ ХҮЧИН ЧАРМАЙЛТ ГАРГАН ИДЭВХ ЗҮТГЭЛ ГАРГАН ЗҮТГЭНЭ

ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын дарга бригадын генерал



Энхийг сахиулах ажиллагаанд Монгол эмэгтэйчүүдийн оролцоо, туршлага, сургаж, илтгэлээс тоймлон хүргэж байна/ Өмнөх арван жилтэй харьцуулахад дэлхийн эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурь, ажил эрхлэлт, улс төр, эдийн засгийн салбарт оролцох оролцоо нэмэгдсэн ч батлан хамгаалах, аюулгүй байдал болон хууль хүчний салбарт эрчүүд давамгайлсан байдал хэвээр байна. Түүхэнд эрт дээр үеэс дайчин эмэгтэйчүүд байсаар ирсэн бөгөөд орчин үеийн дайн мөргөлдөөн, улс төрийн шийдэлд, энхийг сахиулах ажиллагаанд эмэгтэйчүүд оролцож байгаа хэдий ч эмэгтэйчүүдийг ижил тэгш хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх, бодлогын түвшний шийдэлд улс орнууд өөр өөрийн үзэл баримтлалаар хандаж байна.

Үүнтэй уялдуулан өнөөдөр бид НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд дахь эмэгтэйчүүдийн оролцоо, түүний ач холбогдлыг нэмэгдүүлэх талаар НҮБ-аас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд болоод Монгол эмэгтэй энхийг сахиулагчдын энхийн үйлсэд оруулж байгаа хувь нэмрийн талаар түүхэндээ анх удаа улсынхаа ерөнхийлөгчтэй хамт хэлэлцэн ярилцах онцгой өдөр тохиож байгаад туйлын их баяртай байна.

НҮБ-ын түүхэнд анхны эмэгтэй энхийг сахиулагчид 1957 онд ажиллагаанд оролцож байсан бөгөөд 1957-1979 оны хооронд нийт 6250 энхийг сахиулагчийн 5 нь эмэгтэй байсан бол энэ тоо 1989 онд 20, харин 1993 оноос нийт энхийг сахиулагчдын 1%, 2006 оноос 1,8% болон нэмэгдсэн байна.

Мөн 2007 онд Энэтхэг Улс дан эмэгтэйчүүдээс бүрдсэн анхны цагдаагийн

багийг Либерт явагдаж байсан “UNMIL” ажиллагаанд оруулсан нь эмэгтэйчүүдийн оролцооны ач холбогдлыг таниулах түүхэн үйл явдал болсон юм.

1994 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 он гэхэд Ерөнхий нарийн бичгийн дарга нарын хэмжээнд жендерийн тэгш байдлыг хангах 50/50-н хувийн зорилтыг тавьсан. Улмаар 1995 онд Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү зорилтыг энхийг сахиулах ажиллагааны бүх шатны түвшинд хэрэгжүүлэх шийдвэр гаргажээ.

2000 онд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1325 тоот тогтоол батлагдсанаар НҮБ-ын жендерийн эрх тэгш байдлыг хангах амлалт нь албажсан төдийгүй энэ нь эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдлын салбарт байр сууриа олоход түлхэц болсон алдартай тогтоол анх удаа гарсан юм. Энхийг сахиулах ажиллагаанд дахь эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх нь нэг хэрэг ч тэдний оролцоог нэмэгдүүлэх тэр дундаа эмэгтэйчүүдийг ахлах, шийдвэр гаргах, удирдах албан тушаалд ажиллуулах нь бас нэг өөр агуулгын ойлголт мөн бөгөөд өөрчлөлт шаардсан томоохон ажил юм.

Энхийг сахиулах үйл ажиллагааны бүхий л салбарт эмэгтэй энхийг сахиулагчид эрэгтэй алба хаагчидтайгаа адилхан үүргийг ижил цагийн байдал, хүнд хэцүү нөхцөлд гүйцэтгэж чадна гэдгээ нотолсон. Эрэгтэй энхийг сахиулагчид ямар нэмүү үнэ цэнийг авчирч чадах вэ гэж асуух шалтгаан байхгүйтэй адил энхийг сахиулагчдын хувьд эмэгтэйчүүдийн нэмүү үнэ цэнийн талаар ярилцах шаардлагагүй билээ. Цэргийн албаны үүднээс авч үзвэл, ажиллагаанд дахь бүх талын нөхцөл байдал, ёс заншил, соёл эрэгтэй, эмэгтэй гэж ялгагдахгүйгээр

бүхий л чадамжийг шаардаж байдаг.

Харин эмэгтэйчүүдийг энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах, тэдний үйл ажиллагааг дэмжихэд яагаад ийм их цаг хугацаа шаардагдаж, яагаад үр дүн нь хурдан гарахгүй, ямар саад бэрхшээлүүд байгаа талаар авч үзье.

Тухайлбал, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд цэрэг хандивлагч орнуудын гол эрх баригчид жендерийн эрх тэгш байдлын талаарх 1325 тоот тогтоол болон НҮБ-аас баримтлах бодлогын талаар ямар нэг ойлголтгүй байгаа байдал эсвэл үл ойлгох, энхийг сахиулах ажиллагаанд оролцсон эмэгтэйчүүдийн оролцооны талаарх статистик мэдээлэл, дүн шинжилгээ ховор, тухайн орны хүйсийн тэгш эрхийн талаарх нийтлэг ойлголт, зан заншил, шашин шүтлэг, гэр бүлийн асуудал, сонгон шалгаруулалт, зарим орон цэргийн хэргийн дээд шатны мэдлэг олгох сургалтдаа эмэгтэйчүүдийг элсүүлдэггүй, гадаад хэлний мэдлэг, цолны зэрэг дэв, биеийн тамирын шалгалтын босго, ажиллагааны өмнөх бэлтгэлийн ачаалал зэрэг олон төрлийн хүчин зүйлийг нэрлэжээ.

Тэрээр илтгэлийнхээ төгсгөлд “Энхийг сахиулах ажиллагаанд эмэгтэй энхийг сахиулагчдаа илгээж эхэлснээс хойш эдүгээ 15 жилийн туршлага, сургажыг хуримтлуулсан амжилттайгаар цэргийн алба хаагч эмэгтэйчүүд бид Монгол Улс энхийг сахиулах ажиллагаанд цэрэг хандивлаж эхэлсний 20 жилийн ойгоо угтаж байгаа цохон тэмдэглэж бид эх дэлхийн энх амгалангийн төлөөх ариун үйлст улам их хүчин чармайлт гарган идэвх зүтгэл гарган зүтгэхээ энэхүү хүндэт индрээс илэрхийлье” гэсэн юм.

Б.Оюунгэрэл: ЭМЭГТЭЙЧҮҮД ЭРЧҮҮДТЭЙ МӨР ЗЭРЭГЦЭН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭНЭ ГЭДЭГ БАХАРХАЛ

Монголын эмэгтэйчүүдийн холбооны Ерөнхийлөгч



-Энэ өдрийн арга хэмжээнд оролцож байгаа энхийг сахиулагч цэнхэр дуулгачдын бүсгүйчүүд та бүхэнд баярын мэндийг өргөн дэвшүүлье. Монгол дайчдын чансаа НҮБ-ын олон улсын энхийг

сахиулагчдын дунд өндрөөр үнэлэгдэж, үлгэр жишээ болж байна. Энхийг сахиулагчдын дунд монголын эмэгтэй цэргийн алба хаагчид эрчүүдтэй мөр зэрэгцэн үүрэг гүйцэтгэж байна гэдэг бол асар том бахархал.

Түүнчлэн Монгол Улсын анхны эмэгтэй генерал энхийг сахиулагчдын дундаас төрөн гарлаа. Энхийг сахиулах ажиллагаанд оролцох нь Монгол Улсын хувьд улс төр, эдийн засаг, дипломат харилцаа болон үндэсний батлан хамгаалах чадавхаа бэхжүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой бөгөөд үүнээс хамгийн чухал нь улсынхаа тусгаар тогтнолыг дипломат аргаар бэхжүүлэх, цэрэг армия чадавхжуулах оюуны болон бие бялдрын үнэтэй хөрөнгө оруулалт болдог орон өндөр ач холбогдолтой юм. Цэнхэр дуулгачдын энхийг сахиулагч та бүхэндээ Монголын эмэгтэйчүүдийн холбооны өмнөөс, Монголын мянга мянган ээжүүд, хань ижлүүдийн өмнөөс энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй бүх дайчдадаа, бие бүрэлдэхүүнд сонор сэрэмжтэй, авхаалж самбаатай, нойронд сэргэж байж, өөрсдийн амь нас, эрүүл мэндээ бусдын амь нас, эрүүл мэндтэй адилхан хамгаалж, өөрсдийн аюулгүй байдлыг бусдын аюулгүй байдалтай эн тэнцүү үзэж, бусдын төлөө гэх тэр агуу их эр зоригийнхоо нөмөр нөөлөгт өөрсдийгөө үргэлж багтааж явахыг хүсэн ерөөе.

Б.Баярчимэг: ЭНХИЙГ САХИУЛАГЧДЫН ЭГНЭЭНД НЭГДСЭНДЭЭ БАХАРХАЖ СУУНА

Зэвсэгт хүчний 284 дүгээр ангийн эх бэлтгэлийн хэсгийн дарга, зургийн редактор ахмад



-Энхийг сахиулагч эмэгтэй алба хаагчдынхаа төлөөлөл болж энэхүү арга хэмжээнд оролцож байгаадаа туйлын баяртай байна. Эмэгтэй офицер, ахлагч нар энхийг сахиулах ажиллагаанд цэргийн ажиглагч, штабын офицер болон цэргийн багт тагнуулын офицер, хүний нөөцийн офицер, бичээч, соёл хүмүүжил, сэтгэл зүйн офицер, мотобуудлагын ротод тасгийн захирагч, буудагч, ар талын хангалтын албанд эмч, сувилгач, холбоочин, хувцасны болон хүнсний нярав, тогооч зэрэг бүхий л албан тушаалуудад томилогдон алба хаадаг. Энэ нь эмэгтэй цэргийн алба хаагчдыг энхийг

сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх бүрэн боломжтойг харуулж буй том амжилт. Энэ амжилтын үр дүнд 500 гаруй бусгүй энхийг сахиулагч хэмээх эрхэм алдрыг хүртээд байна. Эдний нэг байгаадаа хамгийн их баяртай байдаг. Энхийг сахиулах ажиллагаанд эмэгтэй энхийг сахиулагч нар үндсэн үүргээс гадна орон нутгийн хүүхэд, эмэгтэйчүүдтэй ойр дотно байж, өөртөө болон ирээдүйн төлөө тэмцэх, итгэл найдвараа олоход дэмжлэг үзүүлээд зогсохгүй олон нийттэй харилцах боломжийг өргөжүүлэх, хүний эрхийг дээдлэх, гэмт хэрэг, бэлгийн хүчирхийлээс урьдчилан сэргийлэх, энгийн иргэдийг хамгаалах зэрэг үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, бусад улс орны энхийг сахиулагчдыг манлайлан ажиллаж байдаг юм. Тиймээс эмэгтэй хүний хатан ухаан гэдэг бүсгүйчүүд бидний заяамал чадвар, үр ухаан мөнөөсөө мөн гэдгийг энэ өдөр хэлэхийг хүсэж байна.

Ингээд танхимд мөр зэрэгцэн сууж байгаа цэнхэр дуулгач эмэгтэй энхийг сахиулагч нартаа энхийг сахиулах үйл хэрэгт мөн амжилт хүсээд, Монгол Улсын Зэвсэгт хүчин НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцсоны 20 жилийн ойн мэндийг дэвшүүлье.

О.Гэрэлзаяа: “МИНИЙ ЭЭЖ МУНДАГ ЦЭРЭГ ШҮҮ” ГЭЭД ҮНССЭН НЬ ХАМГИЙН ИХ ЗОРИГЖУУЛСАН ДАА

Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн албаны дарга соёл хүмүүжлийн офицер ахмад



бүрэлдэхүүнээс 22-т, харин бүсгүйчүүдээсээ 1-т орж байлаа. Тэгээд дэлхийд 200-хан ширхэг байдаг дурсгалын

медалийн 163 дахийг гардаж авсандаа туйлын их бахархсан. Бусад орны алба хаагчид өглөө босоод бороо орсон замыг хараад л сэтгэлийн уналтад орж байхад монголчууд улам дүүхэлээд л урагш тэмүүлсэн.

Монголоос мордохдоо “Олон аавын хүүхдүүдтэй албаа нэртэй төртэй хааж, улсынхаа нэрийг өндөрт өргөнөө дөө” гэж бодож онгоцонд суусан. Буцаж ирэхдээ ихийдээ л их яарсан даа. Ээж минь үдэхдээ “Миний охин, эх орныхоо нэрийг өндөрт өргөөд албаа сайн хаадаг юм шүү. Миний охин чадна аа” гэсэн бол 9 настай хүү маань “Миний ээж мундаг цэрэг шүү” гээд үнссэн нь хамгийн их зоригжуулсан даа. Эргэж ирэхэд өөрийн эрхгүй л нулимс урсаад

байсан. Тэр үед охиноо тэврээд үнсэж байгаа дүрс маань хоёр ч дууны клипэнд орсон байдаг. Одоо үзэх бүртээ л эх орондоо ирж байсан тэр торгон мөчөө шинэхнээр нь дурсан санадаг.

Өнөөдөр би Хүндэт харуулын ангийн офицер, мөн шүлэг унших, уран унших сонирхлоороо Зэвсэгт хүчний соёл урлагийн арга хэмжээ, үйл ажиллагааг хөтлөн зохион байгуулж байна. Энэ удаа цэнхэр дуулгач авьяаслаг бүсгүйчүүдийнхээ төлөөлөл болж, Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулга, Хилийн цэргийн дуу бүжгийн чуулга, цагдаагийн “Сүлд” чуулга зэрэг мэргэжлийн урлагийн байгууллагуудын уран бүтээлчидтэй хамтарсан томоохон тоглолтдоо сонгогдон

оролцож, Монгол Улсын Төрийн шагналт, Ардын уран зохиолч, Соёлын гавьяат зүтгэлтэн П.Бадарчийн “Ижийг минь” шүлгийг уншиж, “Энхийг сахиулагч эмэгтэйчүүдийн алдрыг сурталчлах өдөрлөг”-т бэлэж барьж байгаадаа баяртай байгаа.

Харийн газар Монгол эх орныхоо нэрийг өндөрт өргөж яваххаас гадна хамт оныхоо нэгэд эс бүрийг мэдэрч, ойлгож, тусалж дэмжиж чадаж байна гэдэг аугаа үйл хэрэг юм. Мотобуудлагын VIII батальоны захирагч хурандаа Д.Жавхланбаяр, багийн орлогч штабын дарга хурандаа Д.Нанжид нартаа, бадидаа, хамт үүрэг гүйцэтгэсэн хамт олондоо маш их баярлаж явдаг энэ ташрамд илэрхийлье.